



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 254

Улаанбаатар хот

Г “Монре даатгал” ХХК-д дүрмийн сан Г
/хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээндээ
өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3 Даатгалын тухай хуулийн 21.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” 355 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Монре даатгал” ХХК-ийн дүрмийн сангийн хэмжээг тус компанийн хувь нийлүүлэгч Р.Туяацэцэгийн нийт 400,000,000.0 /Дөрвөн зуун сая/ төгрөгөөр нэмэгдүүлж дараахь байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

	Хувь нийлүүлэгч	Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Нэмэлт хөрөнгө оруулалт	Эцсийн үлдэгдэл	
1	У.Сийлэн	832,540,000.0	-	832,540,000.0	34.69
2	Р.Туяацэцэг	967,460,000.0	400,000,000.0	1,367,460,000.0	56.98
3	П.Ганзориг	200,000,000.0	-	200,000,000.0	8.33
	Нийт	2,000,000,000.0	400,000,000.0	2,400,000,000.0	100.0

2. Дүрмийн сангийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг 2013 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Монре даатгал” ХХК /П.Ганзориг/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000434